210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4229789.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	353102467.00	30741771.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	353102467.00	30741771.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	507565.00	200000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	507565.00	200000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		200000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	507565.00	9900.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	507565.00	9900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	194868947.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	194868947.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		194868947.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	366732832.00	242625107.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	366732832.00	242625107.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	344086377.00	225013978.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21646255.00	17005429.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1000200.00	605700.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг даргын орлогч Ж.Энхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, гэрээт аудитор У.Мөнхчимэг хариуцаж гүйцэтгэв.

Орхон сумын ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 01/72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон сумын ерөнхийлөн захирагчийн 2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэшсэн мэдлэг чадвар бүхий албан хаагчаар бэхжүүлсний үндсэн дээр манлайлагч аппаратыг бүрдүүлж, байгууллага, хувь хүмүүсийн үйл ажиллагаанд идэвх санаачлагыг удирдан чиглүүлэх замаар сумын эдийн засгийн чадавхи, иргэдийнхээ амжиргааны түвшин сайжруулах, газар зүйн байршил дэд бүтцийн давуу талыг ашиглаж аймгийн нөлөө бүхий сум болоход оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

Сумын Засаг даргаас Засаг захиргаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, зохицуулалт хийх, мониторингийн хяналт тавих, үнэлж дүгнэх, нутгийн удирдлагын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, мэргэжлийн удирдлагаар хангах замаар иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэхэд оршино.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон сумын төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналт 2020 онд харьяа төсвийн байгууллага ЗДТГ ,Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 1 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж цаашид дутагдлыг дахин давтахгүй алдаа зөрчилгүй ажиллах үүрэг чиглэл өгсөн байна .

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,671.6 сая төгрөгийн 2 хувь буюу 53,4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 126.5 сая, эцсийн үлдэгдэл 127.7 сая төгрөг болж, 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0.01			
Банканд байгаа бэлэн мөнгө	126.5	127.7	1.2	
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	126.5	127.7	1.2	

Эх сурвалж Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 127.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 342.5 сая, эцсийн үлдэгдэл 385.2 сая БУА-2021/6/СТА-ТТЗ

төгрөг болж 42.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.1	2.9	1.8
Бусад авлага	341.4	382.2	40.8
Дүн	342.5	385.1	42.6
Үүнээс байгууллагын төрлөөр			
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	2.2	2.3	0.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.04	0.04	0
Соёлын төв	0.03	0	(0.03)
Сум хөгжүүлэх сан	322.5	361.7	39.2
Сургууль	1.0	0	(1.0)
Хүн эмнэлэг	2.1	0	(2.1)
Цэцэрлэг	0.08	7.4	7.3
Эмийн эргэлтийн сан	0.7	0	(0.7)
Байгаль хамгаалах сан	1.5	1.5	0
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	12.2	12.2	0
Дүн	342.5	385.2	42.6

Эх сурвалж: Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 377.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээгээр 2011 оноос хойш олгосон авлага байна.
- Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор 2014 оноос хойш зээлийн гэрээ байгуулж олгосон авлага байна.
- Төрийн албан хаагч нарт 2014 оноос гэрээгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй 2 жил малжуулах төсөлд хамруулдаг авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг зөрчин 4.5 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнээ худалдагч тал хугацаандаа нийлүүлээгүй байна.

Тайлант онд орон нутаг болон тусгай шилжүүлгийн байгууллагууд авлага бууруулах арга хэмжээг авч ажилласан хэдийч цэцэрлэг, Сум хөгжүүлэх сан 42.6 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 197.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 209.1 мянган төгрөг болж 11.6 сая төгрөгөөр төсөвт байгууллагын бараа материал өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Тусгай зориулалтын материал	30.3	17.2	(13.1)	
Эм боох материал	21.5	20.1	(1.4)	
Бэлэн бүтээгдэхүүн	0.6	1.6	1	
Бичиг хэргийн материал	2.3	1.9	(0.4)	
Аж ахуйн матераил	8.4	8.8	0.4	
Сэлбэг хэрэгсэл	1.3	3.5	2.2	
Түлш шатах тослох материал	3.2	5.8	2.6	
Барилгын засварын материал	4.8	6.6	1.8	

Хүнсний материал	12.9	4.6	(8.3)	
Бусад хангамжийн материал	112.2	124.8	12.6	
Нөөцийн бараа		14.2	14.2	
Дүн	197.5	209.1	11.6	100.0

Эх сурвалж: Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 11.6 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагын худалдан авсан бараа материалиас шалтгаалжээ. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 183.6 сая, хандиваар 18.5 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 208.8 сая хасаж, 209.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Өсөх ирээдүй цэцэрлэг 8.5 сая төгрөгийн бараа материалын ангиллыг үндсэн хөрөнгийн шинж чанартай буруу бүртгэсэн.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2453.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2545.7 сая төгрөг болж 92.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	1772.1	2303.3	531.2	
Хуримтлагдсан элэгдэл	(216.5)	(541.7)	325.2	
Авто-тээврийн хэрэгсэл	268.7	257.0	(11.7)	
Хуримтлагдсан элэгдэл	(133.6)	(144.8)	11.2	
Машин тоног төхөөрөмж/компьютер/	295.6	275.8	(19.8)	
Хуримтлагдсан элэгдэл	(203.1)	(97.5)	(105.6)	
Тавилга, аж ахуйн эд хогшил	205.2	153.5	(51.7)	
Хуримтлагдсан элэгдэл	(115.9)	(58.7)	(57.2)	
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1.9	1.9	0	
Бусад үндсэн хөрөнгө	414.9	121.2	(193.7)	
Хуримтлагдсан элэгдэл	(159.0)	(49.6)	(109.4)	
Дуусаагүй барилга байгууламж	174.5	174.5	0	
Ном	27.9	27.8	(0.1)	
Програм хангамж	4.8	6.8	2	
Хуримтлагдсан элэгдэл	(3.8)	(3.5)	(0.3)	
Бусад биет бус хөрөнгө	119.7	119.7	0	
Хуримтлагдсан элэгдэл	(0.3)		(0.3)	
Дүн	2453.0	2545.7	92.7	100.0
Эмийн эргэлтийн сан	8.9		(8.9)	
Соёлын төв	144.4	148.2	3.8	
ЗДТГ	1428.7	1669.1	240.4	
Сургууль	394.1	271.8	(122.3)	
Эмнэлэг	144.4	134.9	(9.5)	
Цэцэрлэг	329.6	316.9	(12.7)	
ИТХ	2.7	4.7	2.0	
Дүн	2453.0	2545.7	92.7	100.0

Эх сурвалж: Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2545.7 сая төгрөг болж, 92.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 221.7 сая, хандиваар 109.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 294.7 сая, анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгийг дахин шинэчлэн үнэ тогтоосон 31.4 сая, бусад 37.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 300.1 сая, акталсан 82,8 сая, худалдан зарцуулсан 6.4 сая, бусад 136.7 сая төгрөгөөр тус тус хасагдснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Өсөх ирээдүй цэцэрлэг нь 26.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн, Сангийн сайдын тушаалаар батлагдсан ашиглалтын хугацааг мөрдөөгүй байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 13.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.9 сая төгрөг болж 11.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан(-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон өглөг	0.07	1.8	1.73	
Байгууллагад төлөх өглөг	13.6	0.01	(13.6)	
Дүн	13.6	1.9	(11.7)	100.0
ЗДТГ		0.01	0.01	
Сургууль		1.8	1.8	
Эргэлтийн эмийн сан	12.2		12.2	
Соёлын төв	0.07		0.07	-
Хүн эмнэлэг	0.02		0.02	
Цэцэрлэг	1.4	0.03	(1.4)	
Дүн	13.6	1.9	(11.7)	100.0

Эх сурвалж: Орхон сумын засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 1.9 сая төгрөгийн өр байна. Үүнд:

- ЗДТГ 0.1 сая төгрөг, цэцэрлэг 0.03 сая төгрөг, ЕБС нь 1.8 сая төгрөгийг цалингаас суутгаад байгууллагад шилжүүлээгүй өр төлбөр байна.

Аудитын илрүүлэлт:

- Орхон сумын цэцэрлэг нь цалингийн зардлаас өглөг үүсгээгүй байхад эрхлэгчид сумын Засаг даргын захирамжаар 2019 оны үр дүнгийн урамшуулал болох 0.9 сая төгрөгийг 2020 онд олгосон.
- ЕБС нь тайлант онд 1.8 сая төгрөгийн ХХОАТ өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3106.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3265.7 сая төгрөг болж 159.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	879.5	864.3	(15.2)	
Хуритлагдсан үр дүн	1017.3	1192.3	175	
Хөрөнгийн дахин үнэлгэний зөрүү	1209.1	1209.1	0	
Дүн	3106.0	3265.7	159.7	

Эх сурвалж: Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3265.7 сая төгрөг болж 159.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн байгууллагууд бараа материал худалдаж авсан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлж бусад хангамжийн материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5.7 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 106.2 сая төгрөгөөр баталж, 132.4 сая төгрөгийг бүрдүүлэн, 26.2 сая төгрөгөөр буюу 124.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/ Хэтрэлт +, хэмнэлт-
11	Татварын орлого	106.2	132.4	26.2
110	Орлогын албан татвар	48.9	61.6	12.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	48.9	61.6	12.7
110002	Үйл ажиллагааны орлого	10.1	12.4	2.3
110003	Хөрөнгийн орлого	21.8	15.6	(6.2)
110008	Шууд бус орлого	17.0	33.6	16.6
113	Хөрөнгийн албан татвар	3.1	2.7	(0.4)
113002	Бууны албан татвар	3.1	2.7	(0.4)
118	Бусад татвар, төлбөр, хураамж	54.1	68.0	13.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	20.7	18.5	(2.2)
118001	Улсын тэмдэгтийн хураамж	5.0	5.7	0.7
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10.0	6.8	(3.1)
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.7	5.9	0.2
1181	Газрын төлбөр		4.5	4.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	33.4	44.9	11.5
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	32.0	43.7	11.7
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.4	0.5	0.1
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.9	0.6	(0.3)

Эх сурвалж: Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үйл ажиллагааны орлого 122.4 хувь, орлогын албан татварын орлого 125.7 хувь, шууд бус орлого 197.9 хувь, бусад татвар, төлбөр, хураамж 125.6 хувь, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 114.7 хувь, хог хаягдлын хураамжийн орлого 103.4 хувь, байгалийн нөөц ашигласны төлбөр 134.6 хувь тус тус давсан биелэлттэй байна. Хүү торгуулийн орлого 167.0% биелэлттэй байгаа нь газрын зөрчлийн орлого 11 сая төгрөгөөр давж биелэсэн, ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 136% биелэлттэй байна. Айл өрхийн түлээний хэрэглээ нэмэгдсэн нь цаг агаарын хүйтнээс шалтгаалсан. Улсын тэмдэгтийн хураамжын орлого 114.7 биелэсэн нь үйл ажиллагааны орлогууд 100 дээш хувиар нэр төрөл дээр жигд ханган биелэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Бууны албан татвар 0.4 сая төгрөгөөр тасарсан байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 3.1 сая төгрөгөөр тасарсан байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 58.3 сая төгрөгийн 17 алдаа зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- ЕБС нь хичээл үйлдвэрлэлээс 0.9 сая төгрөгийг хөрөгийн зардалд, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 5.9 сая төгрөгийг урсгал засварт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.
- ЭМТ, соёлын төв, ИТХ нь цалингийн зардлаас ажил олгогчийн НДШ-н зардлаас бүгг хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, Сангийн сайдын 2015-1-20-ны өдрийн 7-р тушаалыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдээдлийг хангахгүй байна.
- ЭМТ, цэцэрлэг нь батлагдсан төсөвт тусгагдаагүй ажил хавсарсан нэмэгдэл олгосон
- Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдээдлийг баталгаажуулаагүй. /ЭМТ/
- Тендерт шалгараагүй ААН байгууллагаас эм, эмийн хэрэгсэл худалдан авсан. /ЭМТ/
- Цалингийн зардлаас өглөг авлага үүсгээгүй шууд зардал гаргасан. /Соёлын төв, ИТХ/
- СӨБ нь 2020 оны 3.4 улирлын үр дүнгийн урамшууллын захирамж гаргахдаа 4 улирлын ур чадварыг урьдчилан шийдвэр гаргасан. Мөн цалингийн зардлаас ажилчдад түлээ, нүүрсний мөнгө олгосон.
- ЗДТГ нь няравын тайланд 0.1 сая төгрөгийн бараа материал орлого, зарлагын баримтгүй, 1,1 сая төгрөгийн бараа материал шаардахгүй зарцуулсан 0,1 сая төгрөгийн засварын хөлс орлогодсон, харилцахын нэхэмжлэх бараа материалын орлого зарлага зөрүүтэй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна. Мөн нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас цэвэрлэгээний материал худалдан авахаар төлөвлөн зарцуулдаг нь төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.
- ЗДТГ нь засаг даргын нөөц хөрөнгөнөөс баримтгүй 0,1 сая төгрөгийг няравын дансанд шилжүүлэн, зарцуулах мөнгөн дүнгээс илүү зардал гарган “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1 дэх заалтыг зөрчсөн байна. Мөн албан томилолтын зардлыг илүү олгосон байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Орхон сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 05/04 дугаар тогтоолд зааснаар Орхон сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд 0.1 сая төгрөгийн орлого улсын /орон нутгийн / төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан ба 2020 оны 09 сарын 23-ны өдрийн батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах тухай 10/03 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого нийт 0.1 сая төгрөгөөр батлан гүйцэтгэл 0.1 сая буюу төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагааны орлого	0.1	0.1	0	100%
Нийт дүн	0.1	0.1	0	100%

ЗДТГ-н үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелэсэн нь зочид буудлын үйлчилгээ болон худгийн усны орлогоос шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2061.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2061.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2.6 сая төгрөгөөр бууруулж 2059.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

2020 оны төсвийн жилд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 984.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 773.1 сая төгрөгийн санхүүжилт тус тус ирсэн байна. Мөн 2019 Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 23.2 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 95.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 106.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 14.3 сая төгрөгөөр давсан нь иргэдийн дипозит буурсан хүү багассан, төлөвлөгдөөгүй ноосны урамшуулалын ашиг орсон, эрх шилжүүлж авсан иргэдээс ойн гоожингийн орлогын төлөвлөгөө давж биелэгдсэн, айл өрхийн тоо нэмэгдсэн, загасны зөвшөөрөл их авсан учраас хяналт шалгалт үр дүнтэй хийгдсэн нь шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 17.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 10.8 сая төгрөгөөр давсан нь ЗДТГ-ын зочид буудлын үйлчилгээ, худагын ундны усаас орлого орж, газрын зөрчлийн торгуулын орлогын төлөвлөгөө давж биелэсэн нь шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1883.6 сая төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төсвийн орлого бүрдэлт, салбарын ажлын онцлог ачаалал, нийгмийн шаардлагад нийцүүлэн төсвийн захирагчдыг төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлж, цалин нийгмийн даатгалын шимтгэлээс бусад зардлыг эрэмбэ тогтоож зардлуудыг хойшлуулах, хязгаарлах арга хэмжээ авч ажилласан нь шалтгаалсан байна. Үүнд:

- Цэцэрлэг үдийн цай хоол хүнсний зардлаас 36.6 сая төгрөгийг зарцуулаагүй татан төвлөрүүлсэн.
- Орон нутгийн төсвийн байгууллагууд шатахууны зардал 0.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад 0.3 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0.1 сая төгрөг тус тус хэмнэсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллага 3.3 сая төгрөгийг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс 225.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 17.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.6 сая, нийт 242.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 0.6 сая, норматив зардалд 11.9 сая бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 4.2 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 30.7 сая, бусад урсгал шилжүүлэг 0.2 сая нийт 242.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1057 мэдээллээс 1028 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийн хугацаа болоогүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Тухайлбал: Ерөнхий боловсролын сургууль 151 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 2 хугацаа болоогүй, 8 мэдээллийг хоцроосон 8, мэдээлээгүй 1, Цэцэрлэг 151 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 7 мэдээллийг хоцроосон, мэдээллэгүй 1, Соёлын төв 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хоцроосон байна. Эмнэлэг 151 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хоцроосон, ИТХ 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд 1 мэдээллийг хоцроосон байна. СХС,ОНХС Төрийн сан, эргэлтийн эмийн сан 151 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа болоогүй, 1 мэдээллийг хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3		3				100%
Нийт							

/сая төгрөг/

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан, төрийн сан, цэцэрлэг, ИТХ болон Соёлын төв түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, /сургууль, эрүүл мэндийн төв, ЗДТГ/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 191.9 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 191.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн зүйл байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1208 мэдээллээс 950 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийн хугацаа болоогүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй шилэн дансны тухай хуулийг зөрчсөн нь үнэлгээ үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв

Төвлөрүүлсэн захирагчид 151.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 99.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.3 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 4.1 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15.6 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 79.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 16 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Шилэн данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1208 мэдээллээс 950 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийн хугацаа болоогүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

4.1.2 Эрсдэл: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн.

4.2 Авлагатай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: 2020 онд авлага, өглөг нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.

4.2.2 Эрсдэл: Өр авлага хуримтлагдах.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах зөвлөмж өглөө.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн.

4.3 Зардлын данстай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 99.3 сая төгрөгийн 25 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 Эрсдэл: Хууль зөрчих

4.3.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах зөвлөмж өглөө.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн.

4.4 Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Хадгаламжийн хүү, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, шууд бус орлогууд тасарсан байна.

4.4.2 Эрсдэл: Хяналт сулрах, төсвийн захиран зарцуулалт хэтрэх

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр: Орхон сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БУА-2021/6/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Орхон сумын Засаг дарга	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1208 мэдээллээс 950 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийн хугацаа болоогүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна.	0	Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.	Засаг даргын орлогч, нягтлан бодогч	Ж.Энхтуяа Т.Бурмаа
2	2020 онд авлага, өглөг нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.	42.6	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах зөвлөмж өглөө.	Засаг даргын орлогч, нягтлан бодогч	Ж.Энхтуяа Т.Бурмаа
3	Хадгаламжийн хүү, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, шууд бус орлогууд тасарсан байна.	10.0	Төсвийн орлогыг бодитой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд дайчлан ажиллах зөвлөмж өглөө.	Засаг даргын орлогч, нягтлан бодогч	Ж.Энхтуяа Т.Бурмаа
4	Аудитаар нийт 99.3 сая төгрөгийн 25 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	99.3	Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах зөвлөмж өглөө.	Засаг даргын орлогч, нягтлан бодогч	Ж.Энхтуяа Т.Бурмаа
5	Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн.	0	НӨАТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И	Засаг даргын орлогч, нягтлан бодогч	Ж.Энхтуяа Т.Бурмаа

			баримтаар бүрэн баталгаажуулж хэвших зөвлөмж өглөө.		
	Дүн	151.9			